

ХИЧЭЭНГҮЙ БАЛИНГИЙН ЦЭРЭНДОРЖ ГЭЖ ХЭН БЭ?

С.Отгонжаргал

Монгол Улсын Их Сургуул. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Хичээнгүй сайд Цэрэндорж гэж хэн бэ? Монголын түүх судалгаа, түүх бичлэгт хэрхэн тодорхойлогдож ямар байр суурь эзлэж байв, түүний талаар хадгалагдан үлдсэн архивын болон зарим сурвалжид тулгуурлан түүний түүх судалгаанд эзлэж буй байр суурийг нягтлах зорилго тавьсан болно.

Түлхүүр үг: Өнгөрсөн, одоо, ирээдүй, историзм

XX зуунд Монголд намтар судлалаар түүхийн судалгаа эрчимтэй хөгжиж өөрийн гэсэн өнгө аяс бүхий түүх бичлэгийг бий болгожээ. Гэвч энэ үеийн түүх судалгаа түүх бичлэг нь тухайн үеийн улс төр түүхэн үйл явцаас шалтгаалан түүх судалгааны үндсэн зарчмаас хазайж, үзэл суртлын шаардлагаар нэг хэсэг бичигдэж байв. Аливаа шинжлэх ухааны үндсэн зорилт бол судлаж буй объектийнхаа мөн чанарыг нэгдмэл үзэл дээр илэрхийлж гаргахад оршдог. Өөрөөр хэлбэл шинжлэх ухаан нь үнэн мөн чанартай байх ёстой байдаг байна. Түүхийн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачдын нөр их хөдөлмөр ч түүхийн факт, түүхэн үйл явцын үнэн мөн чанарыг тогтоохын төлөө байдаг. Түүхч хүний энэхүү нөр их хөдөлмөрийн үр дүнд хүн төрөлхтөнд өнгөрсний тухай бодитой төсөөлөл бий болж байдаг хийгээд үүн дээр суурилан өнгөрсөн үеийнхээ бүтээсэн үнэт зүйлсийг хойч үе өвлөн эзэмших, улмаар хөгжин дэвших боломж нээгддэг байна. Гэтэл нэгдмэл мэт санагдах бодит ертөнцийн талаар үнэн мөн чанар бүхий мэдлэг авах үйл явц нь өөрөө ээдрээтэй зөрчилтэй байхын зэрэгцээ урт удаан хугацааны судалгаа шинжилгээг шаардаж байдаг аж. Энэ утгаараа, энэхүү өгүүллийг тэрлэгч хичээнгүй сайд Цэрэндорж гэж хэн бэ монголын түүх судалгаа түүх бичлэгт хэрхэн тодорхойлогдож ямар байр суурийг эзлэж байгаа гэдэгт та бүхний анхаарлыг хандуулахын зэрэгцээ архивын болон зарим сурвалжид түүний талаар тэмдэглэгдэн үлдсэн баримтыг толилуулахыг зорьсон юм. Учир нь түүхийн шинжлэх ухаанд жижиг асуудал гэж байдаггүй хийгээд хэрэв өнгөрсөн, одоо, ирээдүй нэгдмэл байдаг, өнгөрсөн ирээдүй хоёр одоод үнэхээр чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үзвээс ирээдүй зөв байхын тулд өчигдрийг нягтлах нь түүхч бидний үндсэн үүрэг болж байгаа юм. Өнөөдрийн хөгжлийн төвшинг тодорхойлохдоо

өчигдрөө сайн мэдэхийн зэрэгцээ өнгөрсний талаар зөв ойлголт авсан байх ёстой гэж историзмын үндсэн зарчимд заасан байдаг.

XX зууны Монголын түүхийн судалгаа болон түүх бичлэгийн асуудлыг эрдэмтэн судлаачид эргэн нягтлах болсноос хойш багагүй хугацаа өнгөрч их ч зүйлийг хийснийг энд дурьдахад илүүдэхгүй бизээ.

XX зууны эхэн үед монголд үндэсний ардчилсан хувьсгал ялж ардчилсан шинэчлэлт эд өрнөж байх үед жижиг буурай монгол оронд их гүрний хүчирхийллийн сүүдэр туссан нь монголын нийгэм эдийн засаг төдийгүй оюуны хүрээнд ч хүчтэй нөлөөлж, улмаар Коминтерн, ЗХУК/б/Н-ын үзэл суртлын чиглэл заавар онолын баримжаалал болж байв.

Монголын түүхнээ монгол улсын тусгаар тогтнолыг устгасан урвагч хэмээн бичигдсээр ирсэн шанзов Бадамдоржийг эдүгээ хэн хүнгүй мэддэг билээ. Түүгээр ч зогсохгүй Монгол улс Сүй-Шү-жаны цэргийн хүчинд автагдан тусгаар тогтнолоо алдаж байх үест

Богц богц мөнгөөрөө

Богдыгоо худалдсан сайдууд гуай

Дэнс дэнс мөнгөөрөө

Дэлхийгээ худалдсан сайдууд гуай хэмээн тусгаар тогтнолоо эрх мэдэл, эд хөрөнгө, албан тушаалаараа худалдсан дээдсийг шүүмжилж ард түмний дунд дуулагдах болсон дууны үг монголын түүх бичлэгт томоохон байр суурь эзлэж байсан нь саяхан билээ. Энэ дууны үгнээс бас ч олныг мэдэж болохоор байгаа юм. Тухайлбал, сайдууд гуай гэдэг үгнээс үзвэл ганц нэг хүн бус олон тоон дээр байгааг мэдэж болно. Гэтэл өдгөө бид эх орноо харийн түрэмгийлэгчдэд худалдсан ганцхан Бадамдорж гэгчийг л түүх бичлэгээс мэддэг.

Наймдугаар богд Жавзандамбын монгол бичгийн багш, бичгийн нэрт түшмэл, Монгол улсын ардын засгийн газрын анхны сайд, хурц гүн хэмээн Монгол даяар алдаршсан Н. Магсаржавын 1925-1927 онд бичиж хэвлүүлсэн Монгол улсын шинэ түүх номонд дээрхи түүхэн үйл явдлын талаар "Өөрөө гуйн өргөж автономит засгийн газрыг устган дундат засгийн газраа нэгтгэх, захируулахыг ирж мэдүүлэх бичиг шийтгэж Чин-И надад өгвөөс, би засгийн газраа үтэр нэвтрүүлж сайхнаар тохинуулан шийтэхийн тул энэ явдлыг Монгол засгийн эрх баригчид

хурдан түргэн зөвлөлдөж гүйцэтгэн шийтгэвээс зохимой хэмээн хэлээр ирсэн явдлыг мөнхүү хичээнгүй сайд гүн Цэрэндорж урьдаар ерөнхий сайд чин ван лам Бадамдорж лугаа биеэр нууц зөвлөлдөн эдүгээ цагийн байдал, автономит засгийн газрыг устгахаас зайлшгүй болсон хэрэг мэт боловч урьдаар Богд хаан танаа сэмхэн сонсгож таалал ямар болохыг туршсугай хэмээн хэлэлцээд ерөнхий сайд Чин ван лам Бадамдоржийн бие Богд хаан танаа бараалхаж хятад элчин Чин-Игийн дурдсан эл хэргийн байдлыг амар сонсгон айлтгасанд Богд хаанаас хэрэв автономит засгийн хэргийг устгаваас урьдах Чин улсын үеэс илүү ямар эрх олгохыг тодорхойлон асууж хариуг айлтгаж түн хэмээснээр Ерөнхий сайд Бадамдоржийн бие хятад Чин-И лүгээ учирч Богд хааны зарилгийг уламжлан хэлсэн тухай Чин-Игээс уг саналыг илтгэн дүрэм хэмжээг төлөвлөж харилцан зөвлөлдөн тогтсугай хэмээсэн дагалдаагаар хичээнгүй сайд гүн Цэрэндоржид өгсөн хятад бичгийг харьяат сайд өөрөө монгол хэл үсгээр орчуулаад Бадамдорж сайдын гэрийн газар нийлж уншин үзвээс, Гадаа Монгол автономит засгийг устгасны хойно хойчийг сайжруулах дүрэм хэмээх ... нь ердийн явуулах хэргийг төлөвлөснөөс бус Монголд Чин улсын үеэс илүү болох онц эрх олгох хэмээсэн үг үсэг үгүй" /Н. Магсаржав Монгол улсын шинэ түүх. УБ. 1994 он. 143-144/ гэжээ. Уг ном хэвлэгдэн гарах үеийг нягтлан үзвээс МАН-ын үндэсний ардчилсан зорилт бэрхшээлтэй учирч байсан хэдий ч Коминтерн, ЗХУК/б/Намын эрхшээлд авталгүй тууштай хэрэгжиж байсан үе байв. Энэ утгаараа Магсар хурцын "Монгол улсын шинэ түүх" бүтээл нь Хичээнгүй сайд Цэрэндоржийн талаар үнэнд ойрхон мэдээлэл өгсөн ном гэж үзэж болох талтай юм. Хичээнгүй гүн Цэрэндоржийг хэн байваа гэж тодорхойлоход, 1996 онд Улаанбаатар хотноо хэвлэгдэн гарсан "Коминтерн ба Монгол орон" баримтын эмхтгэл чухал эх сурвалж болж байгаагийн зэрэгцээ нилээд судлууртай мэдээллийг агуулж байгаагаараа онцлогтой болно. Энэхүү эмхтгэлд 1921 онд Б. Шумяцкийгээс Монголын төлөөлөгчдөд товч тодорхойлолт өгч Г.В. Чичеринд илгээсэн бичигт Балингийн Цэрэндоржийн тухай "Тэр монгол эхтэй, хятад эцэгтэй. Хятад, монгол хэлээр гаргуу боловсорсон хүн. ... Нэг үе түүнийг автономитыг устгахад оролцсон хүн гэж үзэж байв. Гэтэл миний биеэрээ олж мэдсэнээр монголын автономыг устгах үед бяцхан Сүй хамгийн түрүүнд чухамхүү Цэрэндоржийг хэлмэгдүүлж байжээ. ... Цэрэндорж Унгерн болон

түүний засгийн газартай хамтарч ажилласангүй хол хөндий байжээ. ... Хутагттай түүний харилцаа сайн бус. Цэрэндорж ер нь өөрийгөө жолооддог манай талыг баримталдаг нь тодорхой байна." /45 тал/гэсэн байдаг. Шумяцкийг ийм дүгнэлтэнд хүргэхэд ямар хүчин зүйл нөлөөлвөө гэсэн асуулт сонирхол татаж байгаа юм. Мөн эмхтгэлд 1924 онд МАН, Засгийн газар, Залуучуудын эвлэлийн ажил байдал ба КИГХ-ны /Коммунист Интернационалын Гүйцэтгэх Хороо/ төлөөлөгчийн баримтлах бодлогын тухай Р.Т. Рыскуловаас Мануильский, Войтинский нарт явуулсан илтгэлд Цэрэндоржийн бүлгийн тухай гэсэн тусгай зүйлд "Цэрэндорж бол ... ард түмний эрх ашгийг анхны хуримтлалын эрх ашгийн үүднээс авч үздэг шинэ төрж буй худалдааны хөрөнгөтний төлөөлөгч болсон Данзантай адилтган үзэж болохгүй билээ. ... Цэрэндоржийн бүлгийг халхавч болгон засгийн эрхэнд байлгаж байх ёстой бөгөөд ... хэрэв үүнтэй нэгэн зэрэг ардын намын залуу жигүүр бэхжих юм бол энэ бүлэг бидний гарт орох болно." /75/ ... "Цэрэндорж Үндсэн хуулийн төслийг баталсан Төв Комиссын хуралдаан дээр Үндсэн хуулийн талаар миний боловсруулсан төслийг бараг бүхэлд нь хүлээн авсан билээ. Уг комисст Ринчино болон бусад хүмүүс оролцсон ба харин Үндсэн хуулийн талаар хөрөнгөтний либерал үзэл баримталсан төсөл оруулахыг эрмэлзэн байсан комиссын гишүүн Жамсрано байхгүй байв, бодвол түүнийг зориуд уриагүй биз" /78-79/ гэжээ. Рыскуловын Цэрэндоржид өгч байсан үнэлгээ бодит байдлаас хол зөрөөгүй нь тодорхой юм.

Балингийн Цэрэндорж гэдэг хүний талаархи түүхийн судалгаа яагаад дан цагаанаар бичигдэх болсон хийгээд хичээнгүй сайд хэмээн монголын түүхнээ алдарших болтол нь магтан сайшаах болсон эх үндсийг тодруулахын тулд энэхүү өгүүллийг тэрлэгч уг эмхтгэлд ихээхэн ач холбогдол өгсөн болно. Эдүгээ архивуудад Балингийн Цэрэндоржийн талаархи материал хангалттай хадаглагдан үлджээ. Богд хааныг таалал төгссөний дараа түүний хөрөнгийг хэрхэх талаар Б. Цэрэндорж "Үхсэн Богд Жавзандамба хутагт болвоос олон түмэн ардыг мухар сүсгийн хувиар туйлын их дарлаж эд хөрөнгийг хуралдуулсан этгээд мөн болох тул одоогийн дарагдсан хөрөнгийг шууд хураан авах нь зохихын дээр дахин энэ мэт дарагдсан хөрөнгө буй үгүй зэргийг тухайн этгээдээс нягтлан гүйцэтгэвээс зохимой. Бас бурхан тахилын үнэ бүхий хэрэглэлийг мөн нэгэн адил хурааваас

зохимой. Учир юу хэмээвээс мөнөөх л аанай ард олныг элдвээр мунхруулан төөрөгдүүлж олсон хөрөнгө болмой. Жич энэхүү Богд болвоос олон түмэн ардын толгой дээр сууж ахисаар улмаар ашгийг эрмэлзэн шунахай хятадын гар дор оруулан туйлын зовлонг эдлүүлэн байсныг бэлхнээ олон нөхөд мэдсээр хэрэг тул олныг нурших явдал үгүй” гэсэн байдаг. /ГХЯ-ны архив. Ф.1. ХН.206. х.2/ Энэ их хувьсгалч үгийг хэлж байсан Цэрэндорж агсны Богд хаант засгийн газраа хашиж байсан албыг сөхвөл Олноо өргөгдсөн Монгол улсын үед буюу 1911-1913 онд Гадаад яамны дэс түшмэл, 1913-1915 онд Гадаад яамны дэд сайд, 1915-1919 онд мөн яамны тэргүүн сайдын алба хашиж гүнгийн зэргээр шагнуулж байжээ. Үүнээс үзэхэд тэрээр Богд хаанд туйлын үнэнч зүтгэж байсан хийгээд тиймээс ч түүнийг өндөр үнэлж гомдоохооргүйгээр дэвшүүлэн ажилуулж байсан болов уу..

Балингийн Цэрэндоржийн талаар манай нэртэй түүхчид судлаачид багагүй бүтээлийг туурвисны дотор түүний намтар ажил үйлсий нь архивын материал түүний өөрийнх нь хувийн фонд мөн хүү Юндэнгийнх нь болон ардын засгийн анхны жилүүдэд Цэрэндоржтой хамт ажиллаж байсан хүмүүсийн дурсамж дээр тулгуурлан бичсэн академич Б. Ширэндэвийн “Хичээнгүй сайд Цэрэндорж” бэсрэгхэн ном онцгой байр суурь эзэлдэг юм. Уг ном нь Б. Цэрэндорж бол БНМАУ-ын төрийн зүтгэлтний нэг мөн гэсэн ерөнхий гарчгийн дор гурван хэсэгт хуваан бичигджээ. Уг ном нь хэдийгээр социализмын гэгдэх үед бичигдэж Б. Цэрэндоржийг төрийн зүтгэлтэн талаас нь тодруулахыг зорьсон хэдий ч тухайн цаг үед болсон явдлыг байгаагаар нь тэмдэглэн үлдээсэн нь үнэ цэнэтэй мэдээллийг өгөхийн зэрэгцээ зарим ээдрээтэй андуу ташаа мэдээг нягтлахад чухал байсаар байгаа юм. “Тухайлбал Коминтерн ба Монгол” эмхтгэлд “Нэг үе түүнийг автономитыг устгахад оролцсон хүн гэж үзэж байв. Гэтэл миний биеэрээ олж мэдсэнээр монголын автономыг устгах үед бяцхан Сүй хамгийн түрүүнд чухамхүү Цэрэндоржийг хэлмэгдүүлж байжээ... Цэрэндорж Унгерн болон түүний засгийн газартай хамтарч ажилласангүй хол хөндий байжээ” хэмээн Б. Шумяцкийгээс . Г.В. Чичеринд мэдээлж байсан баримт тэмдэглэгдэн үлдсэн бол энэ талаар Б. Ширэндэвийн номонд “ 1919 онд хятадын милитартстууд ... цэрэг зэвсгээр сүр далайлгаж монголын автономит засгийн газрыг “сайн дураараа” устгах тухай бичиг гаргаж өгөхийг Монголын феодалын эрх баригчдад тулгасан тэр цагт Шанзов

Бадамдорж мэтийн харгис этгээдүүд үндэсний эрх ашгаас урван тэрсэлж, хятадын цэргийн эрхтний өмнө сөгдөн бууж өгсөн аж. Харин дэвшилттэй зарим хэсэг нь автономит төр улсаа хэвээр үлдээхийг оролдсон боловч хүчин эс хүрсэн тул арга буюу уул шаардсан бичгийг гаргаж өгчээ. Автономитыг устгах тухай бичигт хоёрдох хэсгийн эрмэлзлэл шаардлагыг тусган илэрхийлэгчийн нэг байсан Цэрэндорж бас гарын үсэг зуралцсан ажээ. 1920 онд оросын цагаантны үлдэгдэл Барон Унгерн нийслэл хүрээг эзлэж өөрийн цуст дарангуйллын мөн чанарыг далдлан нуухын тулд “ Монголын автономит засгийг сэргээн тогтоов” хэмээн үймүүлж байсан үед Цэрэндорж бас Дотоод Яамны дэд сайдаар ажиллаж байжээ. Б. Цэрэндорж автономит засгийг устгах тухай бичигт гарын үсэг зурсан ба Бароны сэргээн босгосон хэмээх засгийн газарт албан хааж байсан явдал нь үндэсний эрх чөлөөний ардын тэмцэлд харштай хэрэг болов гэдгийг ... Цэрэндорж яваандаа ойлгожээ”/Хичээнгүй сайд Цэрэндорж. УБ. 1965. х. 11/ гэсэн байна. Энэ мэт чухал эх сурвалж болох мэдээ уг номонд олон байгаа хэдий ч БНМАУ-ыг тунхагласны 40 жилийн ойд зориулсан утгаараа тухайн үеийн үзэл сурталт таацуулсан олон дүгнэлт хийгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй юм. Академич Б. Ширэндэвийн уг ном гарсны дараахан буюу 1967 онд Б.Цэрэндоржийн удирдлаганд ажиллаж байсан М. Ядамсүрэнгийн дурдатгал хэвлэгдэн гарсан нь эдүгээ түүхч судлаачдын иш татан ашигладаг зохиолын нэг болсон байна. Уг бэсрэгхэн дурдатгал нь бүхэлдээ Б. Цэрэндорж агсныг магтан сайшаах өнгө аясаар бичигджээ. Тухайлбал Б. Цэрэндоржийн хувьсгалч ардчилсан үзэлтэй болох нь, Б. Цэрэндоржийн Монгол-аюуллалтийн найрамдалд үнэнч болох нь зэрэг гарчигуудаас аливаа түүхэн бие хүнийг нэг магтан дуулахаараа тэнгэрээс төрсөн мэт товойлгодог, нэг муулвал ардын дайсан шунахай балмад үзэшгүй этгээд болгодог тухайн үеийн үзэл суртлын шаардлагын дагуу бичигдсэн нь тодорхой байдаг. Гэхдээ уг дурдатгалд Б. Цэрэндоржийн талаар сонирхол татахуйц мэдээлэл олон байгааг бас ч үгүйсгэж болохгүй юм. Б. Цэрэндоржийн хувийн амьдралын зарим нэгэн онцлог хэсэгт “ Цэрэндорж хашаандаа таван тасалгаа бүхий орос маягийн шавар байшинтай, түүний 2 тасалгааг түүний хүү Юндэн нь эзлэх ба нөгөө 3 тасалгаанд өөрөө суудаг бөгөөд түүний нэг нь зочид хүлээн авдаг европ маягийн төхөөрөмжтэй, харин өөрийн суудаг тасалгаандаа халуун ханзтай, түүний дээр жижиг ширээ тавьж

ширээний баруун үзүүрт нь өөрөө суух ба зүүн талд нь эхнэр Даланжид нь суудаг байлаа”/М. Ядамсүрэн Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж. УБ. 1967.х. 22/ гэжээ. Б. Цэрэндорж агсны гэр орны зохион байгуулалт, тав тухаа бүрдүүлсэн байдлаас түүний дотоод ертөнц, хүсэл зоригийг баримжаалж болох боломжтой юм. Мөн “ Б. Цэрэндорж гуай угаас шашны үзэлтэй хэзээ ч эвлэрч байгаагүй бөгөөд хурал ном гүрэм, домд дургүй ба лам багшгүй хүн байсны дээр сүм хийдэд мөргөдөггүй байв”/ мөн тэнд/ гэсэн мэдээлэл нь цаашид түүнийг олон талаас нь судлах боломжийг нээж байгаагаараа уг дурдатгал нь ач холбогдолтой байсаар байгаа юм. Б. Цэрэндоржийн төрийн түшээгийнхээ хувьд төв эрхэмсэг чанарыг өөртөө шингээж олон түмэнд хэрхэн хүндлэгдэж байсан талаар 1998 онд академич Ж. Болбаатар “ Хичээнгүй сайд Б. Цэрэндоржийн төв эрхэмсэг чанар” өгүүлэлдээ бичжээ. Харин уг өгүүлэлд Б. Цэрэндоржийн Монголын автономитыг устгахад гар бие оролцсон түүхэн нөхцлийг академич Б. Ширэндэвээс нилээд өөр өнцгөөс харж дүгнэсэн байна. / Ж. Болдбаатар Түүх зулсан он жилүүдийн ойллого. УБ. 2003. х. 212/

Б. Цэрэндоржийн амьдралын түүхэн замналыг харуулсан баримт бичгийн эмхтгэлийг Монгол Улсын Үндэсний архивын газар, “ хичээнгүй сайд” сангаас эрхлэн гаргасан нь Цэрэндорж судлалд шинэ үүд хаалгыг нээлээ гэж үзэж болох юм. Уг эмхтгэлд Үндсэн хуулийн талаар Б. Цэрэндоржийн илтгэл, МАН-ын Ш их хурал дээр хэлсэн үг, Цэрэндоржоос хүү Юндэнланчуудаа хэргэм залгамжлуулахыг хүссэн бичгийн хариу, Бичээч Цэрэнпилийн хэргийн талаар Цэрэндоржийн зарлан мэдээлсэн бичиг, Б. Цэрэндоржийн НТХ-нд гаргасан өргөдөл зэрэг Б. Цэрэндоржийн түүхэнд холбогдох архивт хадгалагдаж байгаа баримт бичгийн төрөл бүрээс орсон нь эмхтгэлийн үнэ цэнийг улам нэмэгдүүлж байгаа болно. / “Ерөнхий сайд Б. Цэрэндорж. Баримт бичгийн эмхтгэл. УБ. 1998/

Ийнхүү Цэрэндорж судлал нь жилээс жилд өргөжин байгаа нь сайшаалттай байхын зэрэгцээ аливаа түүхт хүнийг олон өнгө аясанд нь суурилуулан үзэхийг шаарддаг плюрализмын зарчмыг чанад барьж ажиллах чиглэл үгүйлэгдсээр байгаа юм. Түүхэн хүрдийг ямар нэгэн далдын хүч бус оюун ухаант хүн хөдөлгөж байдаг хийгээд түүхэн хүрдийг эргүүлж буй түүхт хүчирхэг хүмүүсийн дотоод ертөнцийн чанадыг үнэнд ойрхоноор ирээдүй хойчдоо нээж чадаваас түүхэн үйл

явц зөв гольдролоороо эргэх боломжтой байдаг. Гэхдээ төөрөгдлөөс эмээх хэрэггүй юм. Төөрөгдөл нь үнэний мөн чанарыг олох гишгүүр байхын зэрэгцээ үнэний мөн чанарыг төрүүлж байдгаараа давуу талтай байдаг байна.

Abstract: Who is the Prime Minister Tserendorj. The article aims to consider the position of the Prime Minister Tserendorj in Mongolian historical studies and in historical sources referring to some archive and source materials.